



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: “Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах”

Аудитын код: ХЭА-2024/15-22-ШТА-НА

Чингис хот 2024 он

Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор Б.Ариунаа

Утас: 93032714 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Аудитор Б.Хуланхатан

Утас: 99008827 Цахим хаяг: khulankhatanb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

ГАРЧИГ

1. БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.	6
1.1 ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ ТӨСВИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙНА.	6
1.2 СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС БАТЛАГДСАН САНХҮҮЖИЛТИЙГ УДИРДАМЖИЙН ДАГУУ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.	7
2. БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, 18,091.4 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.	7
2.1 БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА. ..	7
2.2 СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС БАТАЛСАН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨРӨЛ СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ 2021 ОНЫ А/17 ДУГААР ЗАХИРАМЖААР БАТЛАГДСАН ЖУРМЫН ЗАРДЛЫН АНГИЛАЛТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.	8
2.3 АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС ЗАРИМ СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИАГҮЙ БАЙНА.	9
3. ДҮГНЭЛТ:	10
4. САНАЛ:	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УИХ	Улсын Их хурал
ХХК	Хязгаарладмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” нийцлийн аудитыг гүйцэтгэв.

Аудитын зорилго:

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго оршино.

Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар болон холбогдох бусад байгууллагын сонгуулийн зардалтай холбоотой баримт материалыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 400, 4000, МУ-ын Төрийн аудитын стандартын MNS 6817-8:2020 Нийцлийн аудит, MNS6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудит хийх журам”, аудитын асуултуудад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах зэргээр нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуулийг зохион байгуулах чиг үүрэг бүхий аймгийн Сонгуулийн хороог аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 7 дугаар сарын 16-ны наймдугаар хуралдааны 1 дүгээр тогтоолоор байгуулсан байна. Уг тогтоолоор Хэнтий аймгийн Сонгуулийн хороон сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тогтоосон байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг 18 сумын 93 хэсгийн хороонд 946 албан хаагч томилогдон ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны 3/777, 3/834, 3/852, 3/893, 3/909, 3/940 дугаар бүхий албан тоотуудаар батлагдсан төсвийг хүргүүлсэн ба 10 дугаар сарын 10-ны А/68 дугаар тушаалаар аймгийн Сонгуулийн хорооны төсвийг 1,102,304.0 мянган төгрөгөөр баталсан нь бүрэн олгогдсон байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан төсвөөс аймгийн Сонгуулийн хороонд 183,587.2 мянган төгрөгийг, 18 сумын Сонгуулийн хороонд 918,646.8 мянган төгрөгийг хуваарилан зарцуулж 18,091.4 мянган төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 79,302.6 мянган төгрөг, Цагдаагийн газарт 62,250.0 мянган төгрөг тус тус хуваарилагдсаныг батлагдсан зардлын ангиллын дагуу бүрэн зарцуулж, тайлагнажээ.

БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1 ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ ТӨСВИЙГ 6 УДАА НЭМЭГДҮҮЛЭН БАТАЛСАН БАЙНА.

Хэнтий аймгийн 2024 оны аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын /цаашид ИТХ гэх/ сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс 1,102.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Уг санхүүжилтийг Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газраас 6 удаа нэмэгдүүлэн, 1 удаа өөрчлөн баталсан байна.

Хүснэгт 1 Сонгуулийн зардлын хуваарилалт

№	Батлагдаж ирсэн зардлын ангилал	2024.08.19 №3/777	2024.09.05 №3/834	2024.09.13 №3/852	2024.09.23 №3/893	2024.09.27 №3/909	2024.10.05 №3/940	2024.10.10 А/68	Зөрүү
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх	1,348	1,348	1,348	1,348	1,348	1,348	1,909	(562)
2	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	-	-	44,194	44,194	44,364	44,364	44,704	(340)
3	Сурталчилгааны материал тараах унааны зардал	-	-	-	-	13,020	13,020	13,020	-
4	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	-	-	1,300	1,300	1,300	1,300	1,300	-
5	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	-	-	-	8,960	8,960	8,960	9,233	(273)
6	Сүлжээний судлагаа хийх зардал	-	-	-	1,266	1,266	1,266	1,266	-
7	Шуурхай багийн зардал	-	-	-	-	3,200	3,200	3,618	(418)
8	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх	-	-	-	-	-	4,990	4,990	-
9	Санал авах байр бэлтгэх зардал	-	25,760	25,760	25,760	26,040	26,040	26,040	-
10	Санал авах байрны түлшний зардал	-	-	-	-	9,600	9,600	9,600	-
11	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	14,921	14,921	14,921	14,921	14,921	14,921	14,921	-
12	МТБ, даамлын сургалт	21,356	21,866	21,866	21,866	21,866	21,866	21,305	562
13	Сурталчилгааны зардал	-	-	20,000	20,000	20,000	20,000	20,000	-
14	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	-	-	-	-	-	699,171	700,711	(1,540)
15	МТБ, даамлын урамшуулал, хоолны зардал	-	-	-	-	-	98,941	99,121	(180)
16	Бичиг хэргийн зардал	-	14,740	14,740	14,740	14,860	14,860	14,860	-
17	Шуудан холбооны зардал	-	18,000	18,000	18,000	18,150	18,150	18,150	-
18	Унааны зардал	-	75,670	75,670	75,670	76,370	76,370	77,348	(978)
19	Албан томилолын зардал	-	-	14,768	14,768	14,768	14,768	14,768	-
20	Болзошгүй зардал	-	-	-	-	-	7,812	4,083	3,729
21	Саналын хуудас устгах зардал	-	-	-	1,288	1,288	1,288	1,288	-
	ДҮН	37,625	172,305	252,567	264,080	291,320	1,102,234	1,102,234	-

Хүснэгтээс үзэхэд мэдээлэл технологийн баг /цаашил МТБ/, даамлын сургалтын зардлаас 561.5 мянган төгрөг, болзошгүй зардлаас 3,728.8 мянган төгрөг нийт 4,290.3 мянган төгрөгийг маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх, саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал, эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал, шуурхай багийн зардал, сонгуулийн хорооны гишүүд болон МТБ, даамлын урамшуулал, хоолны унааны зардалд нэмж өөрчлөн баталсан нь зардлыг оновчтой төлөвлөөгүйг харуулж байна.

Аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газрын нягтлан бодогчидтой уулзах үеэр сонгуулийн зардлыг төлөвлөдөггүй дээд газраас хуваарилагдсан зардлыг ангиллын дагуу зарцуулж, тайлагнадаг тухай танилцуулсан.

Сонгуулийн зардлын төлөвлөлтийн тооцоог тухайн орон нутгийн сонгууль эрхлэн

гүйцэтгэдэг доод шатны байгууллагаас гаргуулан төлөвлөөгүйгээс маягт хэвлүүлэх зардал, эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал, сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардал, МТБ, даамлуудын сургалтын зардал дутагдалтай батлагдсан.

1.2 СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС БАТЛАГДСАН САНХҮҮЖИЛТИЙГ УДИРДАМЖИЙН ДАГУУ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

Сонгуулийн ерөнхий хорооноос 1,102,234.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас аймгийн Сонгуулийн хороонд 183,587.2 мянган төгрөг, 18 сумын Сонгуулийн хороонд 918,646.8 мянган төгрөгийг хуваарилсан байна.

Санхүүжилтийн хуваарилалтыг СЕХ-оос өгсөн удирдамж чиглэлийн дагуу тулгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Унааны зардлыг СЕХ-ны Тамгын газрын 2024 оны 3/834 дүгээр албан бичгээр өгсөн “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар”-ын 3-т заасны дагуу сумын Сонгуулийн хороодод хуваарилаагүй аймгийн Сонгуулийн хорооноос 76,370.0 мянган төгрөгийн шатахуун талоныг НИК ХХК-аас худалдан авч сумдад хуваарилан зарцуулсан байна.

Эрчим хүчний нөөц болон санал авах байр бэлтгэх зардлаас 3,735.0 мянган төгрөгийг аймгийн төв, аймгийн төвийн суманд хуваарилсан.

Сумын Сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын унааны зардлаас сумын хол ойрыг харгалзан тооцож зөрүү 568.7 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд нэмж хуваарилан зарцуулсан.

МТБ, даамлуудын сургалтын зардлаас сургалтад хамрагдсан 103 хүний томилолтоос 40.0 мянган төгрөгийн хоолны үнэ 4,120.0 мянган төгрөгийг суутган аймгийн Сонгуулийн хорооны зардалд хуваарилан зарцуулсан байна.

БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, 18,091.4 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

2.1 БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Аймгийн Сонгуулийн хороо нь 183,587.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 170,587.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 13,461.5 мянган төгрөг, сумдын Сонгуулийн хорооноос төвлөрүүлсэн 4,629.9 мянган төгрөг нийт 18,091.4 мянган төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны Төрийн сан банкны 100900022001 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардлын 40.0 мянган төгрөг, дүн мэдээ дамжуулах зардлаас 6,610.0 мянган төгрөг, санал авах байр бэлтгэх зардлаас 1,050.0 мянган төгрөг, сургалт, сурталчилгааны зардлаас 1,554.4 мянган төгрөг, болзошгүй зардлаас 4,083.2 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Сумын 918,646.8 мянган төгрөгийн санхүүжилт авч 914,016.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,629.9 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хорооны Төрийн сан банкны 100180022001 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

Сумдын Сонгуулийн хороодоос Баянмөнх сум 320.0 мянган төгрөг, Дэлгэрхаан сум 1,173.2 мянган төгрөг, Баян-Адарга сум 384.8 мянган төгрөг, Биндэр сум 490.0 мянган төгрөг, Жаргалтхаан сум 490.0 мянган төгрөг, Мөрөн сум 826.9 мянган төгрөгийг тус тус хэмнэн

ажилласан байна.

Норовлин сумын Сонгуулийн хороо нь сонгуулийн хорооны гишүүд, даамлуудын урамшуулал, хоолны зардлаас 351.2 мянган төгрөгийг илүү суутгаж, сумын төрийн сангийн ХХОАТ-ын 100181300901 дансанд шилжүүлсэн. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай 14.1¹-д заасныг зөрчсөн байна.

2.2 СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС БАТАЛСАН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨРӨЛ СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГЫН 2021 ОНЫ А/17 ДУГААР ЗАХИРАМЖААР БАТЛАГДСАН ЖУРМЫН ЗАРДЛЫН АНГИЛАЛТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

СЕХ-ны Тамгын газрын даргаас ирүүлсэн зарцуулалтын тухай тайлбараар 18 суманд хуваарилсан тооцоог Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 2, 3 дугаар хавсралтаар баталсан аймгийн сонгуулийн хорооны 12 төрлийн зардал, сумын сонгуулийн хорооны 9 зардлын ангиллыг тулгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

№	Сумын нэр	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал					
		Саналын хуудас төхөөрөмжийн хүргэх, авах зардал			Сурталчилгааны материал тараах унааны зардал		
		Анх хуваарилсан	Заавраар хуваарилсан	Зөрүү	Анх хуваарилсан	Заавраар хуваарилсан	Зөрүү
1	Аймгийн сонгуулийн хороо	12,014,000	28,227,720	(16,213,720)			
2	Галшар	2,090,000	1,156,080	933,920	840,000	840,000	-
3	Баянхутаг	1,580,000	539,030	1,040,970	420,000	420,000	-
4	Баянмөнх	1,750,000	779,792	970,208	560,000	560,000	-
5	Дархан	1,750,000	820,616	929,384	560,000	560,000	-
6	Дэлгэрхаан	1,920,000	984,266	935,734	700,000	700,000	-
7	Жаргалтхаан	1,920,000	949,792	970,208	700,000	700,000	-
8	Цэнхэрмандал	1,750,000	820,616	929,384	560,000	560,000	-
9	Өмнөдэлгэр	2,260,000	1,304,307	955,693	980,000	980,000	-
10	Батширээт	1,750,000	857,811	892,189	560,000	560,000	-
11	Биндэр	1,920,000	1,026,904	893,096	700,000	700,000	-
12	Баян-Адарга	1,750,000	830,595	919,405	560,000	560,000	-
13	Дадал	1,750,000	934,016	815,984	560,000	560,000	-
14	Норовлин	1,750,000	875,048	874,952	560,000	560,000	-
15	Батноров	2,260,000	1,294,328	965,672	980,000	980,000	-
16	Баян-Овоо	1,750,000	825,152	924,848	560,000	560,000	-
17	Мөрөн	1,920,000	883,566	1,036,434	700,000	700,000	-
18	Хэрлэн	390,000	392,920	(2,920)	1,680,000	1,680,000	-
19	Борөндөр	2,090,000	1,201,440	888,560	840,000	840,000	-
	Нийт дүн	44,364,000	44,704,000	(340,000)	13,020,000	13,020,000	-

Тухайлбал 18 сумын сонгуулийн хороонд саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардалд 16,476.3 мянган төгрөгийг хуваарилан 14,274.2 мянган төгрөгийг зарцуулж, сурталчилгааны материал тараах унааны зардалд 13,020.0 мянган төгрөгийг хуваарилан 12,319.9 мянган төгрөгийг зарцуулж, нийт дүнгээр сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны санал авах байранд хүргэх, буцаан татах зардалд тайлагнасан нь уг захирамжийн 3 дугаар хавсралтаар баталсан сумын сонгуулийн хорооны зардлын ангилалтай нийцэхгүй байна.

¹ Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна.

2.3 АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС ЗАРИМ СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИАГҮЙ БАЙНА.

Аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогч сумын Сонгуулийн хорооны зардлын тайланг нэгтгэхдээ сумдын тайланг батлагдсан маягтын дагуу гаргуулж аваагүй, батлагдаагүй зардлаар тайланг нэгтгэн хүлээн авсан, Норовлин сумын Сонгуулийн хорооны гишүүд, даамлуудын мөнгөн урамшуулал, хоолны зардлаас ХХОАТ-ыг илүү суутгаж шилжүүлснийг шалгаж аваагүй байна.

Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10-т “... аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар нийт 118,932.5 мянган төгрөгийн зөрчил илэрч, 351.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 118,580.3 мянган төгрөгийн зөрчлийг цаашид анхаарч ажиллах талаар 4 саналыг СЕХ-д хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ:

1. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

2. Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, 18,091.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

САНАЛ:

Сонгуулийн ерөнхий хороонд:

1. Сонгууль эрхлэн гүйцэтгэдэг доод шатны байгууллагуудаас сонгуулийн зардлын төсвийн саналыг авч сонгуульд шаардагдах зардлыг үндэслэлтэй төлөвлөх.
2. Аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан зардлын санхүүжилтийг заавар аргачлалын дагуу сумын Сонгуулийн хороонд хуваарилагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.
3. Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зардлын ангиллыг СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан журамд нийцэж байгаа нягтлах.
4. Сумын Сонгуулийн хороонд хуваарилсан зардлын гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлж, зөрчлийг тухай бүрд арилгуулах арга хэмжээ авч, ажиллах.



**ХЭНТИЙ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

Чингис хот, Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23119
Утас,Факс: 7056 2401

2024.11.13 № 74
танай _____-ны № _____-г

Хариу хүргүүлэх тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус төсөлд саналгүй болно.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудиор Агуунаас

Ташинз!

Жуу 20/13



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 дугаар сарын 13

Дугаар А/39

Чингис хот

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт, аймгийн Сонгуулийн хорооны дарга Ж.Гантулга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэхийг аудитор (Б.Ариунаа)-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

232410039



2024 оны 11 дугаар сарын 12

Дугаар 74 ХЭА-2024/15-22-ШТА-НА Чингис хот
А 2370452

Г Төлбөр барагдуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Норовлин сумын Сонгуулийн хороо нь Сонгуулийн хорооны гишүүд, даамлуудын мөнгөн урамшуулал, хоолны зардлаас 351.2 мянган төгрөгийн татварыг илүү суутгаж сумын Төрийн сангийн Хувь хүний орлогын албан татварын 1001813000901 тоот дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 7.1-д заасан “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү суутгаж шилжүүлсэн 351.2 мянган төгрөгийн татварыг Сумын сонгуулийн хорооны гишүүд, даамлуудад буцаан олгох.
2. Актын биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Норовлин сумын Сонгуулийн хорооны дарга Х.Баасансүрэн, нягтлан бодогч Э.Ононцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.ХУЛАНХАТАН

232450074

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112